

Эх сурвалжийг нь дурдалгүйгээр ишлэх, ашиглахыг хориглоно.

“Шинэ эдийн засагт үүсч буй субъектууд” судалгааны төслийнхөний хийсэн ажиглалт, дэвшүүлсэн асуудлууд

Рэбэка Эмпсон, Лорэн Бонилла, Дуламын Бум-Очир, Рэбэка Плүкан, Хэдвиг Вотэрс

Эх сурвалжийг нь дурдалгүйгээр ишлэх, ашиглахыг хориглоно.

“Шинэ эдийн засагт үүсч буй субъектууд” (Европын Судалгааны Зөвлөл, ERC-2013-CoG, 615785, Үүсэн буй субъектууд) төслийн судлаачид төсөлд хамаарах өөр өөрсдийн судалгаа шинжилгээний хүрээ, бичвэрүүддээ анхаарч буйтай холбогдуулан, тэдний хийсэн ажиглалт, дэвшүүлсэн асуудлуудаас тоймлон хүргэж байна. Эдгээр нь судлаач тус бүрийн үзэл санааг илэрхийлж буй бус агаад, харин судалгааны илүү өргөн сэдвүүдтэй холбогдох материалуудынхаа талаар санал солилцож байгаа бидний ярианы нэг хэсэг юм. Тиймээс ч судалгааны үлдсэн хугацааны туршид эдгээр асуудлууд хувьсан өөрчлөгдөх нь гарцаагүй билээ. 2017.05.12.

Монголд буй хувийн болоод улсын өрийн талаарх хандлагууд ёс суртахууны хувьд хоёрдмол утгатай байна. Нэг талаараа, өр нь ёс суртахууны хувьд ичгэвтэр зүйлд тооцогддог бөгөөд авилгалд идэгдсэн улс төрчид, “эх оронч бус луйварчид”-тай холбогдож, улсын өрийг хувийн олз ашгийнхаа төлөө ашигладаг хүмүүсийг ихэд өсгөхийн зэрэгцээ хөгжил, эдийн засагтай холбоотой үзэл, яриаг хашин боогдуулж, Монголын баялагийг өөр газар буй бусдын ашигт зориулан хоосолж байна. Харин нөгөө талаараа, хувьдаа өртэй байх нь танил тал хийгээд аливаа солилцооны хэлбэрүүдийг хадгалж, найз нөхдийн хооронд баялагийг эргэлдүүлж байгаагаараа шинэ зүйлийн эхлэл, боломж бололцоог илэрхийлэх талтай байгаа нь ажиглагдав. Энэ утгаараа, өр нь эдийн засгийн өсөлт, хямралын аль алиных нь талаарх яриа, дискурсыг нөхцөлдүүлж байна.

Төр засаг гэж юу вэ, юу өгч чадах вэ гэдэг талаарх хүлээлт өөрчлөгдөж байна. Төрийн зүгээс явуулж буй дэд бүтцийн болоод хөгжлийн төлөөх төслүүдийг ёс суртахууны хувьд дорой, материалын хувьд эдэлгээгүй, цаг хугацааны хувьд хэврэг бөгөөд, нийтийн өмчийг хувийн бизнесийн ашиг сонирхол, танил талдаа зориулан үрэх явдал л хэмээн улам бүр тооцох болов. Төр засаг нөөц баялагаа нийгмийн хамгааллыг сайжруулахын төлөө зарцуулахын оронд банк болон бусад институтуудээр дамжуулан, хүмүүсийг зээл авахын тулд албан ёсны баримт бичгүүдээ барьцаанд тавихад хүргэх буюу барилгын төслүүд санаачлах юм уу худалдан авах замаар нэмэлт зээл авах бололцоотой болгох зэргээр иргэд өөрөө өөрсдөдөө санхүүгийн боломж бий болгох үүд хаалгыг нээж байна. Гэвч, эд зүйлсийг хичнээн барьцааллаа ч, өөрчлөгдөн байдаг өртгийн үнэлгээ тэднийг ямар ч найдваргүй агаад түр аргацаасан агуулгатай болгох ажээ.

“Хямрал”-д барих хариу, хувьсал өөрчлөлт, тогтворгүй хувиралыг туулж буй явдал нь өнөөдөр хүлээлт бус, норм болоод байна. Судалгааны маань нэлээд хэсэг эдийн засгийн төлвийн таамагт анхаарсан билээ. Үүнд оролцогчдын болон судлаач бидний аль алиных нь хувьд юмс маш хурдан өөрчлөгдөж байгаа ба тэдгээр өөрчлөлтүүдийг бий болгож буй зүйлс болон өөрчлөлтөөс үүдэж буй үр нөлөөг ойлгохын тулд илүү их мэдээлэл хэрэгтэй гэсэн сэтгэгдэл ихэнхдээ үлдэж байв. Тэдгээр тогтворгүй хувиралыг даван туулахын тулд тэмдэглэгээ унших, төсөөлөл тооцоо гаргах, холболт хайх, юмсын ардах “үнэн”-г илчлэх зэргээр Монголчуудын өөрсдийнх

Эх сурвалжийг нь дурдалгүйгээр ишлэх, ашиглахыг хориглоно.

нь хэрэглэж буй таамаглал, стратегийг бид бичвэрээрээ дүрслэн гаргаж ирэхийг хичээж буй билээ. Энэ нь биднийг энэхүү байнгын өөрчлөлт дунд явагдаж буй төрөл бүрийн амьдралын зам, шийдвэр, ёс зүйн ажил санаачлага болон тухайн өөрчлөлтийн бий болгож буй үзэл санаа, яриа тайлбаруудыг тунгаан үзэхэд хүргэж буй юм.

Капиталист харилцаа болон даян дэлхийг хамарсан санхүүгийн зах зээл тэлэх хэлбэрүүд нь нэг хэвэнд орсон ертөнцийг үүсгэж байна уу, эсвэл энд туршилт болон ялгааны тухай ярих боломж байна уу? Уул уурхайн төслүүдэд төрийн эзэмших хувь илүү өндөр байх ёстой хэмээн мэтгэлцэж, олон улсын хуульчдын зөвлөгөөг эсэргүүцэж, “Урт нэртэй хууль”-ийг өөрчлөх хуулийн төсөл боловсруулж буй зэрэг жишээг бид гадаадын ширүүн дарамт, санхүүгийн арилжааны эрхшээлийг эсэргүүцэн тэмцэж байгаагийн хэлбэр гэж үзэх үү? Эсвэл, эдгээр нь хаягдаж хоцрохгүйн тулд эдийн засагт бодлогоор илүү их оролцоотой байж, илүү тэгш хувь хүртэхийг хүсч буй онцгой бөгөөд шинэлэг хүмүүсийн жишээ юу?